



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/
218

Улаанбаатар хот

Г

Г

Болзолт уралдаан зарлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх болзолт уралдааны удирдамжийг хавсралтаар баталсугай.
- “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт болон болзолт уралдааныг зохион байгуулахад мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах ажлын хэсгийн дарга /Я.Буянжаргал/-д үүрэг болгосугай.
- Болзолт уралдааны санхүүжилтийг төсвийн болон олон улсын байгууллагын хандив тусlamж, “Эрүүл мэндийг дэмжих сан”-гаас гаргахыг Эдийн засаг, санхүү хэлтэс /Б.Пүрэвсүрэн/-т зөвшөөрсүгэй.
- Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д үүрэг болгосугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 04 сарын 20.-ны өдрийн
112 дугаар тушаалын хавсралт

2/8



ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ ШАЛГАРУУЛАХ БОЛЗОЛТ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Үндэслэл.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 112 дугаар тогтоолоор “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг баталсан. Уг хөтөлбөрийн хэрэгжилтийг идэвхжүүлж, салбар дундын болон олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Зорилго.

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, иргэдийн дунд хепатитийн С, В вирусийн халдвартыг илрүүлэхэд идэвх, санаачилгатай ажилласан аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг, сум, өрх, тосгоны эрүүл мэндийн төвийг шалгаруулж, урамшуулах.

Хугацаа. 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 11 дүгээр сарын 22-ны өдөр хүртэл 6 сар.

Зохион байгуулагч. Эрүүл мэндийн яам, “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсэг

Хамрах хүрээ. 21 аймаг, 9 дүүргийн эрүүл мэндийн байгууллага.

1. Эрүүл мэндийн газар
2. Бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг
3. Дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв
4. Сум, тосгоны эрүүл мэндийн төв
5. Өрхийн эрүүл мэндийн төв

Болзолт уралдааны шалгуур.

1. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буй аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар:

1.1 “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулсан Засаг даргын захирамж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн хувь;

1.2 Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, өрх, сумын эрүүл мэндийн төвийн хамтран ажиллах гэрээ, түүний хэрэгжилтийн хувь;

1.3 “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хуваарь гаргаж зохион байгуулсан байдал /ялангуяа байгууллага, мэргэжилтэн, хувь хүнийг идэвхжүүлэх талаар/;

1.4 Хөтөлбөрийн хүрээнд үзлэгт хамруулсан 40-65 насны иргэдийн тоо, үзлэгт хамрагдалтын хувь;

1.5 Даатгалгүй иргэдийг даатгалд хамруулсан тоо, даатгалд хамрагдалтын хувь;

1.6 Хөтөлбөрийн үйл ажиллагаанд аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулсан байдал;

1.7 Үзлэгийн урьдчилгаа санхүүжилтийн зарцуулалтын байдал;

1.8 Үзлэгт хамрагдсан 40-65 насны иргэдийн мэдээллийг хугацаанд нь ирүүлсэн хувь;

1.9 Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөрийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэг бэлтгэж, зөвлөгөө өгсөн байдал;

1.10 Үзлэгийн явцад мэдээлэл, сурталчилгааны материал тараасан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байдал;

1.11 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамруулах, сорьц зөөвөрлөхөд аймаг, нийслэл, сумын Засаг даргын үзүүлсэн дэмжлэг.

2. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буй Бүсийн оношилгоо эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг:

2.1 “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулсан даргын тушаал, шийдвэр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн хувь;

2.2 Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, өрх сумын эрүүл мэндийн төвийн хамтран ажиллах гэрээ, түүний хэрэгжилтийн хувь;

2.3 Шинжилгээ хийх хуваарь гаргаж батлан, хуваарийн дагуу шинжилгээнд хамруулсан хувь;

2.4 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамрагдан, шинжилгээний хариу зэрэг, сөрөг гарсан иргэдийн сорьцыг ангилан “ийлдсийн сан” үүсгэсэн байдал;

2.5 Хепатитийн В, С вирусийн архаг халдвартай оношлогдсон иргэдийг вирусийн эсрэг эмчилгээ, хяналтад хамруулсан хувь;

2.6 Орон нутгийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран ажилласан байдал;

2.7 Даатгалгүй иргэдийг даатгалд хамруулсан тоо, даатгалд хамрагдалтын хувь;

2.8 Хөтөлбөрийн үйл ажиллагаанд аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулсан байдал;

2.9 Үзлэгийн урьдчилгаа санхүүжилтийн зарцуулалтын байдал;

2.10 Үзлэгт хамрагдсан 40-65 насны иргэдийн мэдээллийг хугацаанд нь ирүүлсэн хувь;

2.11 Вируст хепатитийн архаг халдварын эсрэг эмчилгээнд хамрагдсан 40-65 насны иргэдийн мэдээллийг мэдээллийн санд үнэн зөв, бүрэн гүйцэд оруулсан хувь;

2.12 Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөрийн талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэг бэлтгэж, зөвлөгөө өгсөн байдал;

2.13 Үзлэгийн явцад мэдээлэл, сурталчилгааны материал тараасан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байдал.

3. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буй тосгон, өрх, сумын эрүүл мэндийн төв:

3.1 “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулсан Засаг даргын захирамж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн хувь;

3.2 Эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлэг, өрх сумын эрүүл мэндийн төвийн хамтран ажиллах гэрээ, түүний хэрэгжилтийн хувь;

3.3 Харьяа нутаг, дэвсгэрийн 40-65 насны иргэдийг elegbuten.mohs.mn програмд бүртгэсэн байдал;

3.4 Иргэдийг хепатитийн В, С илрүүлэг шинжилгээнд хамруулах хуваарь баталж, хуваарийг хэрэгжүүлж ажилласан хувь;

3.5 Хөтөлбөрийн хүрээнд 40-65 насны иргэдийг В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамрагдах, сорьцыг зөөвөрлөхөд сум, дүүрэг, хорооны Засаг даргын үзүүлсэн дэмжлэгийн байдал;

3.6 Даатгалгүй иргэдийг даатгалд хамруулсан тоо, даатгалд хамрагдалтын хувь;

3.7 Үзлэгт хамрагдсан 40-65 насны иргэдийн мэдээллийг хугацаанд нь ирүүлсэн хувь;

3.8 Үзлэгийн урьдчилгаа санхүүжилтийн зарцуулалтын байдал;

3.9 Үзлэгийн явцад мэдээлэл, сурталчилгааны материал тараасан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байдал.

Шалгаруулж, дүгнэх үйл ажиллагаа.

1. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын тайланг 2017 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газарт ирүүлнэ.

2. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн ажлын хэсгээс үнэлгээний баг томилж, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн тайлантай танилцаж, үнэлгээ өгнө.

3. Болзолт уралдаанд амжилттай оролцсон эрүүл мэндийн байгууллагуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

4. Болзолт уралдааны удирдамжид тусгасан үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн эрүүл мэндийн байгууллагыг шагнаж, урамшуулна.

Шалгаруулах байгууллагууд	Шалгаруулах тоо	Шагналын хэмжээ
Аймаг, нийслэлийн ЭМГазар	1	10,000,000 төг
Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Аймгийн нэгдсэн эмнэлэг	1	8,000,000 төг
Дүүргийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг	1	8,000,000 төг
Сум, тосгоны эрүүл мэндийн төв 1 дүгээр байр	1	5,000,000 төг
Сум, тосгоны эрүүл мэндийн төв 2 дугаар байр	3	2,000,000 төг* 3
Сум, тосгоны эрүүл мэндийн төв 3 дугаар байр	4	1,000,000 төг * 4
Өрхийн эрүүл мэндийн төв 1 дүгээр байр	1	5,000,000 төг
Өрхийн эрүүл мэндийн төв 2 дугаар байр	3	2,000,000 төг* 3
Өрхийн эрүүл мэндийн төв 3 дугаар байр	4	1,000,000 төг * 4
Байгууллагын өргөмжлөл	19	19 байгууллага * 50,000төг
Нийт		56,950,000

Санхүүжилт: Төсвийн болон, олон улсын байгууллагын хандив тусlamж, Эрүүл мэндийг дэмжих сангаас /56.950,000 төгрөг/

Үр дүн:

“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийг улсын хэмжээнд зохион байгуулах үйл ажиллагааг хугацаанд нь чанартай, бүрэн хийж гүйцэтгэсэн байна.

.....000.....